



**УЛААНБААТАР ХОТЫН
ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/64

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 66 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журмын 3.2.4 дэх заалт, “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр бий болсон 9,900.000, 9,700.000 /Арван есөн сая зургаан зуун мянга/ төгрөгийн 15/21, 18/22 тоот сэлбэгийн нөөц бий болгох гэрээний дагуу хийгдсэн Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байгууллагын хөрөнгөнд зохих журмын дагуу бүртгэн авахыг Ахлах нягтлан бодогч /М.Ичинхорлоо/-д үүрэг болгосугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий диспетчер /Г.Ганзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАН-ОЧИР

2150300137